



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ СУДАЛГАА БАЙХГҮЙГЭЭС
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ИРГЭНИЙ СОНИРХОЛ, ХӨДӨЛМӨРЛӨХ
ХЭРЭГЦЭЭНД ТУЛГУУРЛАН ОЛГОЖ БАЙНА.

Аудитын код:ДГА-2020/03-ГА

Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2020 оны 06 сар	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
	Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас:70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn
	Аудитор: Б.Уранбилэг Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
	Аудитор: У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	4
Дүрслэлийн товъёог	6
Хавсралтын товъёог.....	7
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5-9

БҮЛЭГ 1. СУРГАЛТЫН ОРЧИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХҮРЭЛЦЭЭ ХАНГАМЖ ХАНГАЛТТАЙ БОЛОВЧ ЗАРИМ МЭРГЭЖЛИЙН БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧИН ДУТАГДАЛТАЙГААС ЭРЭЛТТЭЙ БОЛОН ЗАХИАЛГАТ МЭРГЭЖЛЭЭР БОЛОВСРОЛ ОЛГОЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

1.1 Сургалт явуулах орчин, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалттай байна.

1.2 Зарим мэргэжлийн багш дутагдалтай байгаагаас 2 мэргэжлийн чиглэлээр сургалт явуулах боломжгүй байна.

1.3 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 8.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ СУДАЛГАА ХИЙГДЭЭГҮЙ НЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛЭЭР ОЛГОЖ ЧАДАЖ БАЙГААГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮРГЭЖ БАЙНА.

2.1 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгааг хийгдээгүйгээс мэргэжлийн боловсрол олгох байгууллага нь зөвхөн суралцагчийн хэрэгцээ сонирхолд үндэслэн элсэлтийг зохион байгуулжээ.

2.2 Аймгийн хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжил олгож байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

2.3 Мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

ДҮГНЭЛТ:.....	24
ЗӨВЛӨМЖ:	25

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	26
------------------------------------	----

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	27
---	----

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
МБГ	Мэргэжлийн боловсролын газар
ХММО	Хүнд машин механизмын оператор
АХБ	Азийн хөгжлийн банк
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
АЗД	Аймгийн засаг дарга
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Хүснэгтийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Онолын танхимын талбайн хэмжээ	7
Хүснэгт 2	Хичээлийн дадлагын байрны талбайн хэмжээ	8
Хүснэгт 3	Хичээлийн лабораторийн талбайн хэмжээ	8
Хүснэгт 4	Багш нарын боловсролын зэрэг	10
Хүснэгт 5	Багш нарын мэргэжлийн зэрэг	11
Хүснэгт 6	Багш нарын мэргэжил	11
Хүснэгт 7	2018-2019 оны хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын зарцуулалт	13
Хүснэгт 8	Нэмэлт санхүүжилтийн дансны орлого болон зарцуулалт	13
Хүснэгт 9	Аймгийн МСҮТ-ын 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд элсэгчдийн судалгаа	15
Хүснэгт 10	Ажлын байрны захиалгын тоог МСҮТ-ийг төгсөгчдийн тоотой харьцуулсан үзүүлэлт	18

Дүрслэлийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Төгсөгчдийн тоо мэдээ	17

Графикийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Багш нарын ажилласан жилийн судалгаа	12
График 2	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал	19
График 3	Элсэгчдийн насны байдал	20

Хавсралтын товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Мэргэжлийн боловсрол олгох тусгай зөвшөөрлийн жагсаалт	

Зургийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1-2	Дадлагын байр	9
Зураг 3-4	Тогоочийн ангийн дадлагын байр	9

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтан, олон нийтэд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Сургалтын хэрэгцээ шаардлагыг хангахуйц орчин нөхцөл бүрдсэн эсэх.
- Мэргэжлийн боловсрол олгох зорилго зорилт хангагдаж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн хяналтын газрыг хамруулан, 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилийн мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын хязгаарлалт

Цар тахалтай холбоотойгоор улсын онцгой комиссын “... олон хүн нэг дор цуглуулахгүй байх” гэсэн чиглэлийн хүрээнд хөл хорио цуцлаагүй тул аудитын нээлтийг хийгээгүй ба аудитын талаарх мэдэгдлийг албан бичгээр хүргүүлэн ажиллав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд, төгсөгч нартай ярилцлага хийх, бусад шаардлагатай баримт материал, статистик судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 304 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах арга хэмжээний тухай”
- Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”
- Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/197 дугаар тушаал, ХНХС-ын 2019 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”
- Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын А/171, А/496 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”
- Мэргэжлийн боловсролын сургалт, ерөнхий шаардлагын стандарт.
- Бусад холбогдох тогтоол болон бусад хууль, эрх зүйн актууд.

Аудитыг 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд аудитор Б.Уранбилэг, У.Оюунтүлхүүр нар гүйцэтгэж дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Аудитын тайлан, судалгааг 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, 2020 оны 06 дугаар сарын 30-ны дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Үндсэн мэдээлэл

Дорноговь аймаг дахь МСҮТөв нь 1986 онд Дундговь аймгийн барилга, техник мэргэжлийн сургуулийн салбар сургуулиар байгуулагдаж, барилгын засал чимэглэлийн 27 сурагчтайгаар анхны үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 1987 онд Улаанбаатар хотын барилгын 1 дүгээр техник мэргэжлийн дунд сургуулийн салбар сургууль, 1989 онд Барилга, хөдөө аж ахуйн техник мэргэжлийн сургууль, 1992 онд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болж үйлдвэрлэл үйлчилгээ чиглэлээр мэргэжилтэй ажилтныг орон нутагтаа бэлтгэж байна.

Дорноговь аймаг дахь МСҮТөвийн зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино.

БСШУЯ-ны МБГ-ын даргын тушаалаар мэргэжлийн боловсрол олгох тусгай зөвшөөрлийг авсан ба 2022.07.01-ний өдрийг хүртэл хүчинтэй. Тус байгууллага нь 2.5 жилийн хугацаатай суралцах ангийг 11 чиглэлээр явуулж бүрэн дунд боловсрол, 1 жилийн хугацаатай суралцах ангийг 22 чиглэлээр явуулж мэргэжлийн боловсрол олгодог /Хавсралт №1/.

БҮЛЭГ 1. СУРГАЛТЫН ОРЧИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХҮРЭЛЦЭЭ ХАНГАМЖ ХАНГАЛТТАЙ БОЛОВЧ ЗАРИМ МЭРГЭЖЛИЙН БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧИН ДУТАГДАЛТАЙГААС ЭРЭЛТТЭЙ БОЛОН ЗАХИАЛГАТ МЭРГЭЖЛЭЭР БОЛОВСРОЛ ОЛГОЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

1.1 Сургалт явуулах орчин, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалттай байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь сургалтын орчны стандартын шаардлага хангасан хичээлийн танхим, лаборатори, дадлагын газар, сургалтын талбай, туршилт-үйлдвэрлэлийн цех, сургалтын аж ахуй, номын сан, соёл-спортын болон мэдээллийн төвтэй байна” гэж заасан.

Дорноговь аймаг дахь МСҮТөв нь хичээлийн 2, дадлагын 8 байртай бөгөөд хичээлийн байранд номын сан, спорт зал, соёлын танхим болон 5 лабораторитай байгаа нь дээрх шаардлагыг хангасан байна.

Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан MNS 6541:2015 "Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага, стандарт"-ын 10.5/а/-д “Сургалтын онолын танхимын нэг суралцагчид ногдох хэмжээ 2м.кв.-аас багагүй байна” гэж заасан байна.

МСҮТөвийн хичээлийн 2 байранд нийт 16 онолын танхим, 5 лаборатори байдаг бөгөөд нийт 968.7 м.кв. талбайтай байна. Дараах хүснэгтэд нэг сурагчид ногдох талбайн хэмжээг тооцов. /Хүснэгт №1/

Онолын танхимын талбайн хэмжээ

/Хүснэгт №1/

№	Танхимын нэр	дугаар	М2	Багтаамж хүүхдийн тоо	Нэг удаагийн сургалтын багтаамж /хүүхдийн тоо/	
					2017-2018	2018-2019
1	Онолын танхим /1 хүүхдэд 2м2 аас доошгүй/	103	46.44	20	465	524
2		104	46.44	20		
3		105	46.44	20		
4		106	46.44	20		
5		107	46.44	20		
6		203	46.44	20		
7		205	46.44	20		
8		206	46.44	20		
9		208	46.44	20		
10		108	63.25	20		
11		109	47.6	20		
12		110	46.75	20		
13		112	68.04	20		
14		108	63.25	20		

15		209	46.44	20		
16	2-р байр 5анги /46.44*5/	5 анги	232.2	110		
Төгсөх ангийн суралцагч					138	83
Нийт онолын танхимд суралцагчийн тоо			985.49	410	327	441
1 суралцагчид ногдох талбай				2.3	3.0	2.2

Хүснэгтээс харахад 2017-2018 онд 1 суралцагчид 3м.кв, 2018-2019 онд 2.2 м.кв байгаа талбай ногдож байгаа нь дээрх стандартыг хангаж байна.

Мөн дээрх стандартын 10.5/б/-д *дадлагын газрын талбайн хэмжээ тухайн мэргэжлийн онцлог, шаардагдах техник, тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамааран 40м.кв.-аас доошгүй байна. Тоног төхөөрөмж хоорондын зай нь хөдөлмөр аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах ба том оврын техник, тоног төхөөрөмж шаардагдах дадлагын газрын талбайн хэмжээ 110 м.кв.-аас доошгүй байна*” гэж заасан. /Хүснэгт №2/

Хичээлийн дадлагын байрны талбайн хэмжээ

/Хүснэгт №2/

№	Дадлагын байрны нэр	Талбайн хэмжээ /М2/
1	Тогооч	132
2	Барилгын өрөг угсрагч	105.31
3	Гагнуур	105.31
4	Автомашин засвар	131.52
5	Автомашин засвар	154.86
6	Оёдол	121.9
7	Барилгын мужаан	121.9
8	Барилгын засал чимэглэл	137.09

Стандартын 10.5/в/-д “*Сургалтад зориулсан лабораторийн талбайн хэмжээ нь тухайн мэргэжлийн онцлог, шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн овор хэмжээнээс хамааран 40м.кв.-аас доошгүй байх бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна*” гэж заасан байна. /Хүснэгт №3/

Хичээлийн лабораторийн талбайн хэмжээ

/Хүснэгт №3/

№	Танхимын нэр	М2	Багтаамж /хүүхдийн тоо/
1	Техникийн суурь мэдлэг лаборатори	47.6	20
2	ХММО	46.75	20
3	Цахилгааны дадлагын байр	68.04	20
4	Компьютерын лаборатори	63.25	20
5	Компьютерын лаборатори	46.44	20

Дээрх хүснэгтээс харахад дадлагын байрны талбайн хэмжээ 105-154 м.кв, сургуулийн лабораторийн талбайн хэмжээ 46.44-68.04 м.кв. байгаа нь стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.

2015 онд аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр сургуулийн барилгын гадна, дотор хананд ташуу болон босоо чиглэлээр цууралт

үүссэн, гадна хананы тоосго цүлхийсэн, төмөр утсаар бэхэлж аргацаасан, бетон хаяавч хананаас хөндийрч суурь руу ус нэвчих нөхцөл бүрдсэн, барилгын паспортгүй, хувийн хэрэгт үзлэг, засвар хийсэн тухай тэмдэглэл хөтлөөгүй зэрэг зөрчил дутагдлууд илэрч “дунд” эрсдэлтэй гэсэн үнэлгээ өгсөн байна. Үүний дагуу 2017 онд барилгад мэргэжлийн хүмүүсээр суурийн бэхэлгээ хийлгэж, инженерийн шугам сүлжээний засварын ажлыг хийсэн байна.

Дадлагын байрны тоног төхөөрөмжийн хүрэлцээг тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо ширхэг, суралцагчийн нэг төхөөрөмж дээр хугацаа, суралцагчийн тоо зэрэг үзүүлэлтэд үндэслэн тооцооход барилга, гагнуур, тогооч, оёдолчин зэрэг мэргэжлийн ангиудад хүрэлцээтэй байна. Мөн 2019-2020 оны хичээлийн жилд “Азийн хөгжлийн банк”-ны “Хөдөлмөр эрхлэлт ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд автомашины засварчин, барилгын засал чимэглэлч, хүлэмжийн аж ахуйн фермер мэргэжлийн ангиудад сургалтын тоног төхөөрөмж багаж хэрэгсэл нийлүүлэгдсэнээр тус мэргэжлийн ангийн багаж хэрэгслийн хүрэлцээ хангамж сайжирсан байна. /Зураг №1-2/



Харин тогоочийн ангийн суралцагчид 2004-2010 онуудад ашиглалтад орсон, ашиглалтын хугацаа дуусаж, хоцрогдсон тоног төхөөрөмж дээр дадлага хийж байна. /Зураг № 3-4/



Багш нарт зөөврийн компьютер, анги танхимд LCD телевиз, мэдээлэл технологийн танхимд суурин компьютер хүрэлцээтэй, зарим дадлагын байр сүүлийн үеийн шинэ тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан зэрэг нь сургалтын орчны давуу тал болж байна. Өмнөх онуудад ерөнхий болон мэргэжлийн боловсролын хичээлүүдийн сурах бичгийн хүрэлцээ дутмаг байсан бол 2020 онд шинээр 1840

ширхэг сурах бичгийг БСШУЯ-аас, 116 ширхэг сурах бичгийг “Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд АХБ-аас тус тус хуваарилснаар сурах бичгийн хүрэлцээ, хангамж сайжирсан байна.

1.2 Зарим мэргэжлийн багш дутагдалтай байгаагаас 2 мэргэжлийн чиглэлээр сургалт явуулах боломжгүй байна.

ХНХЯ-ны сайдын 2017 оны А/21 тушаалаар нийт 34 багшийн орон тоо батлагдсанаас 2017-2018 онд 27 багш, 2018-2019 онд 29 багш ажилласан байна.

МСҮТөвийн ерөнхий эрдмийн 10 хичээлийн 11 багш, мэргэжлийн /2.5 жил, 1 жилийн сургалт/ 27 чиглэлээр 17 багш ажиллаж байна.

Мэргэжлийн боловсролын 27 чиглэлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй боловч төмөр замын чиглэлийн 5 ангийн сургалтыг УБТЗ-ын коллежийн багш болон төмөр замын МСҮТөвийн багш нар явуулдаг байна. Мөн бетон арматурчин, барилгын мужааны мэргэжлээр албан байгууллагаас ажлын байрны захиалга болон суралцагсдын эрэлт их байгаа хэдий ч багшлах боловсон хүчин дутагдалтайгаас элсэлт авч хичээллэх боломжгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18-д мэргэжлийн боловсролын сургуулийн багшид дараах шаардлагыг тавьсан байна. Үүнд:

1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай байна Багш нарын боловсролын зэргийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. /Хүснэгт №4/

Багш нарын боловсролын зэрэг

/Хүснэгт №4/

Хичээлийн жил	Багш нар	Багшийн тоо	Боловсролын зэрэг			
			Тусгай дунд	Дипломын	Дээд. Бакалавр	Магистр
2017-2018	Ерөнхий эрдмийн тэнхим	10	-	-	11	9
	Мэргэжлийн тэнхим	17	4	4	11	6
2018-2019	Ерөнхий эрдмийн тэнхим	12	-	-	12	8
	Мэргэжлийн тэнхим	17	4	1	12	6

Нийт мэргэжлийн багшийн 70.5 хувь буюу 12 багш бакалавр түүнээс дээш зэрэгтэй үүний 50% нь магистр зэрэгтэй байна. Тусгай дунд боловсролтой 4 багш мэргэжлийн өндөр зэрэглэлтэй, мэргэжлээрээ 5-11 жил ажилласан байна.

2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын болон мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь мэргэжлийн өндөр зэрэгтэй байна. /Хүснэгт №5/

Багш нарын мэргэжлийн зэрэг

/Хүснэгт №5/

Хичээлийн жил	Багш нар	Багшийн тоо	Мэргэжлийн зэрэг				
			Заах аргач багш	Тэргүүлэх багш	Зөвлөх багш	Мастер тогооч	Олон улсын болон өндөр зэрэглэлтэй гагнуурчин
2017-2018	Ерөнхий эрдмийн тэнхим	10	6	1	-	-	-
	Мэргэжлийн тэнхим	17	5	4	1	2	2
2018-2019	Ерөнхий эрдмийн тэнхим	12	4	2	-	-	-
	Мэргэжлийн тэнхим	17	6	4	1	2	2

Багш нар нь үйлдвэрлэл технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй багш нар байх бөгөөд Монгол Улсын мастер тогооч-2, олон улсын болон өндөр зэрэглэлийн гагнуурчин-2 багш, зөвлөх, тэргүүлэх, заах аргач багш, Монголын Улсын мэргэшсэн нягтлан бодогч, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч өргөмжлөлт багш ажиллаж, бүх багш нар багшлах эрхийн үнэмлэхтэй байна.


- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын болон мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь багшлах эрхтэй, багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш нь сургалтын заах арга зүй эзэмшиж, багшлах эрхийн үнэмлэх авсан байна. /Хүснэгт №6/

Багш нарын мэргэжил

/Хүснэгт №6/

№	Үзүүлэлт	2018			2019		
		Нийт	Ерөнхий эрдмийн	Мэргэжлийн	Нийт	Ерөнхий эрдмийн	Мэргэжлийн
1	Урлаг	1		1	1		1
2	хүмүүнлэгийн ухаан	2	2		3	3	
3	Нийгэм эдийн засаг	1	1		1	1	
4	Биологи	1	1		1	1	
5	Физик, хими, биологи, газар зүй	2	2		2	2	
6	Математик, статистик	2	2		2	2	
7	Компьютер	1	1		2	1	1
8	Бүх төрлийн инженер	13		13	13		13
9	Үйлдвэрлэлийн технологи	1		1	0		
10	Барилга архитектур	2		2	2		2
11	Биеийн тамир	1	1		1	1	
12	Хөдөө аж ахуй	0			1	1	
	Нийт	27	10	17	29	12	17

Багшийн мэргэжил эзэмшээгүй багш нарын мэргэжлийг судлахад инженер-12, үйлдвэрлэлийн технологич-1, барилгын архитектур-2, нийт 15 багш байх бөгөөд бүгд багшлах эрхийн үнэмлэхтэй байна. /График №1/



Багш нарын ажилласан жилийг харахад мэргэжлийн боловсролын багш нарын 41.1 хувь нь 25-аас дээш жил ажилласан, туршлагатай багш нар, ерөнхий эрдмийн багш нарын 50 хувь нь 10-аас дээш жил ажилласан байна.

Багш нарыг сургах, хөгжүүлэх талаар дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Сүүлийн гурван жилийн хугацаанд хөрш зэргэлдээ БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ажил мэргэжлийн дээд сургуультай холбоо тогтоосноор багш болон оюутан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ӨМӨЗО-ы Шилийн гол, Хөх хот, Бугат зэрэг хотын ижил төстэй сургуулиуд дээр сургалт аялал, туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулснаар 5 удаагийн хөтөлбөрөөр 79 суралцагч, 26 багш хамрагджээ.
- Япон Улсад өөрийн сургуулийн багш ажилчдыг дадлага хийх, мэргэжил дээшлүүлэх, хамтран ажиллах зорилгоор "MICA MONGOLIA" Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй сүүлийн хоёр жил хамтран ажиллаж Фукоука, Канагава мужуудад 9 багш, ажилтан мэргэжил дээшлүүлэх 45 хоногийн хөтөлбөрт хамрагдсан байна.

1.3 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 8.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн МСҮТөв нь 2018 онд 76,879.7 мянган төгрөг, 2019 онд 59,212.0 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлын төсөв батлагдсан ба бүрэн зарцуулсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал болон нэмэлт төсвийн дансны орлого зардлыг шалгалаа.

Төсвийн тухай хуульд төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Эдийн засгийн ангилал батлах тухай Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд “Төсөвт байгууллагын албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад дотоодод сургалт, семинарт хамруулах болон эдгээр зорилгоор нэгдсэн семинар, сургалт, хурал зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах сургалтын төлбөр, унаа хоолны зардал, сургалттай холбогдсон материал бэлтгэх, багшийн хөлс төлөх, сургалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн бүх шатны боловсролын байгууллагуудын үзүүлэн

таниулах материал, хичээлийн ба лабораторийн багаж, бодис худалдан авах, сургуулиудын хичээлийн байрандаа буюу хичээлийн байрнаас гадагш явж дадлага хийхтэй холбогдсон зардлыг энэ ангилалд бүртгэнэ” гэж заасан байна.

Тус байгууллагын 2018, 2019 онуудын хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төсвийг дараах зардалд зарцуулсан байна. /Хүснэгт №7/

2018-2019 оны хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын зарцуулалт

/Хүснэгт №7/

Үзүүлэлт		2018 он		2019 он	
		Дүн /мян.төг/	хувь	Дүн /мян.төг/	хувь
Батлагдсан төсөв		76,879.7	100.0	59,212.0	100.0
1	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	76,879.7	100.0	59,212.0	100.0
Зарцуулалт		76,879.7	100.0	59,212.0	100.0
1	Материал	71,098.2	92.5	52,608.4	88.8
2	Уралдаан тэмцээний шагнал, урамшуулал	3,506.5	4.6	2,810.8	4.7
3	Гэрчилгээ, тэмдэгтийн хураамж	1,700.0	2.2	770.0	1.3
4	Сургалтын төлбөр	575.0	0.7	1,801.0	3.0

Нийт зардлын 88.8-92.5 хувийг дадлагын материалд, 4,6-4,7 хувийг уралдаан тэмцээний зардалд, 2,2-3.5 хувийг гэрчилгээ тэмдэгтийн хураамжид, 0.7-0.8 хувийг сургалтын төлбөрт тус тус зарцуулсан байна.

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 2018 онд 3,506.5 мянган төгрөг уралдаан тэмцээний зардалд, 1,700.0 мянган төгрөгийн гэрчилгээ, тэмдэгтийн хураамжийн төлбөрт, 2019 онд 2,810.8 мянган төгрөгийг уралдаан, тэмцээний зардалд 770.0 мянган төгрөгийг гэрчилгээ, тэмдэгтийн хураамжийн зардалд тус тус зарцуулсан нь батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь тус сургуулийн төсөвт биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд төсөв батлагддаггүй, аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал хүрдэггүйтэй холбоотой байна. /Хүснэгт №8/

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого болон зарцуулалт

/Хүснэгт №8/

Үзүүлэлт		2018 он		2019 он	
		Дүн /мян.төг/	хувь	Дүн /мян.төг/	хувь
Орлого		6,600.0	100.0	83,256.5	100.0
1	Түр сургалт	6,600.0	100.0	21,489.0	25.8
2	АЗДТГ-ын дэмжлэг			26,407.5	31.7
3	Төмөр замын ангийн сургалтын төлбөр			35,360.0	42.5
Зарцуулалт		6,600.0	100.0	83,256.5	
1	Багшийн цалин	960.0	14.5	3,895.5	4.7
2	Гэрчилгээний үнэ	870.0	13.2	490.0	0.6
3	Материал	4,770.0	72.3	19,668.7	22.8
4	Анги тохижилт ширээ сандал			24,341.5	29.2
5	Яаманд төвлөрүүлсэн			34,650.0	42.5

6	буцаан төвлөрүүлсэн			210.8	0.3
---	---------------------	--	--	-------	-----

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2018 онд ХЭДСангаас тогоочийн мэргэжлээр сургах 18 иргэний сургалтын төлбөр 3,240.0 мянган төгрөг, цахилгаанчны мэргэжлээр сургах 14 иргэний сургалтын төлбөр 3,360.0 мянган төгрөг, нийт 6,600.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. 2019 онд түр сургалтын төлбөр 21,489.0 мянган төгрөг, АЗД-ын дэмжлэг 26,407,5 мянган төгрөг, төмөр замын ангийн суралцагсдын сургалтын төлбөр 35,360.0 мянган төгрөг, нийт 83,256.5 мянган төгрөгийн орлого орсон байна. 2019 онд төмөр замын сургалтын төлбөр 34,650.0 мянган төгрөгийг ХНХЯ-д төвлөрүүлсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17.1.1 “Суралцагч нь сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй” гэж заажээ.

Гэтэл тогоочийн ангийн суралцагсад дадлагын хичээлд хэрэглэх хоолны материалыг, барилгын цахилгааны анги болон гагнуурын ангийн суралцагсад дадлагын ажлын нэг удаагийн хэрэглэгдэхүүн болох цахилгааны утас, гагнуурын электродыг өөрсдөө авдаг нь суралцагсдын хуульд заасан дээрх эрхийг зөрчиж байна. Уг зардлыг суралцагсдаас гаргаж байгаа шалтгааныг мэргэжлийн ангийн багш нараас тодруулахад зардал хүрдэггүй гэсэн тайлбар өгсөн.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ СУДАЛГАА ХИЙГДЭЭГҮЙ НЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛЭЭР ОЛГОЖ ЧАДАЖ БАЙГААГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮРГЭЖ БАЙНА.

2.1 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа хийгдээгүйгээс мэргэжлийн боловсрол олгох байгууллага нь зөвхөн суралцагчийн хэрэгцээ сонирхолд үндэслэн элсэлтийг зохион байгуулжээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн” гэж заажээ. Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулна ...” гэж хуульчилсан байна.

Аймгийн МСҮТ-д 2017-2018 оны хичээлийн жил 12 мэргэжлээр 228 суралцагч, 2018-2019 оны хичээлийн жилд 20 мэргэжлээр 379 суралцагч шинээр элсүүлж, сургалтын үйл ажиллагаагаа явуулсан байна. /Хүснэгт №9/

Аймгийн МСҮТ-ын 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд элсэгчдийн судалгаа

/Хүснэгт №9/

№	Хичээлийн жил	Мэргэжлийн ангийн тоо	Элсэн суралцагчийн тоо	Сургалтын хэлбэр		
				2.5 жил суралцах /мэргэжлийн боловсрол олгох/	1 жил суралцах /мэргэжлийн сургалт/	Түр сургалт /мэргэжлийн тодорхой түвшний ур чадвар эзэмшүүлэх/
1	2017-2018	12	228	116	112	
2	2018-2019	20	379	169	178	32

Дээрх судалгаанаас харахад 2018-2019 оны хичээлийн жилд нийт элссэн суралцагчдын тоо өмнөх оноос 66 хувиар нэмэгдсэн байна. Аудитын хамрах хугацаанд нийт элсэгчдийн 40 хувь нь суурь боловсрол эзэмшихээр, 60 хувь нь 1 жилийн хугацаатай мэргэжлийн сургалт болон богино хугацаат сургалтад хамрагдсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд ажил эрхэлдэггүй 32 иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн захиалгаар тогооч, барилгын цахилгаанчин мэргэжлээр богино хугацаат сургалтыг зохион байгуулсан байна.

Аудитын хамрах хугацаанд шинээр суралцагч элсүүлэхдээ тухайн жил ЕБС-ийн 9-р анги төгсөх сурагчдад сургууль сурталчлах аяныг аймгийн ХХҮГ-тай хамтран зохион байгуулсан байна. Тус аяны хүрээнд суралцагчдаас элсэн суралцах сонирхолтой мэргэжлийн ангийн судалгааг авч, эрхийг бичиг олгон, элсэлт авсан байна. Харин тухайн мэргэжил нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд судалгаа хийгдээгүй, ажил олгогчийн захиалгыг хэрхэн

судалсан нь тодорхойгүй байна. Үүнийг сургуулийн холбогдох мэргэжилтэн “манай аймагт хөдөлмөрийн зах зээлийн судалгаа байдаггүйгээс дээрх ажлууд хийгдэх боломжгүй байдаг” гэж тайлбарлаж байна. Мөн аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааны талаар аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн холбогдох мэргэжилтэн болон аймгийн ХХҮГ-ын удирдлагаас тодруулахад аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаа байхгүй гэсэн тайлбарыг өгч байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн /*төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх*/ 30.1.4¹, 30.1.14², Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “... хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана” гэж заасан байгаа учраас орон нутгийн хэмжээнд хийх боломжгүй байна. Харин 2020 оны 06 дугаар сард аймгийн Засаг даргын 2020 оны 06 сарын 10-ны өдрийн А/462 дугаар захирамжаар хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх бүрэлдэхүүнийг томилсон байна. Уг захирамжийн хуулийн үндэслэлд дээрх төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг үндэслэл болгосон байна.

Засгийн газрын 2016 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн дүрэм”³-д орон нутагт үндэсний зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэх салбар зөвлөлтэй байна гэж заасан байна. Үүний дагуу орон нутаг дахь салбар зөвлөл байгуулагдсан байх ба 2013 онд бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан ба зөвлөлийн дүрмийг 2012 онд МБСҮЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан байна.

Салбар зөвлөлийн дүрмийн 3 дахь хэсэгт орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг үнэн зөв, бодитоор тогтоох, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын мэргэжилтэй ажилтны захиалгыг судалж, шинээр элсүүлэх захиалгын саналыг мэргэжил бүрээр гарган мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хүргүүлж хамтран ажиллана гэж тусгасан байна. Гэтэл зөвлөлийн үйл ажиллагааг нотлох баримт материал байхгүй, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хэрхэн судалж, сургалтын байгууллагатай хэрхэн хамтран ажилласан талаар баримт материал байхгүй байна.

Зөвлөлийн даргатай ярилцахад “Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа байдаггүй. Ажил олгогч нартай хамтран ажилладаг, эрэлт хэрэгцээг нь

¹ Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, богино, дунд хугацааны болон хэтийн зорилтыг боловсруулах;

² Хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг тодорхой давтамжтайгаар хийх, мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах,

³ Дүрмийн 3.8-д “үндэсний зөвлөл нь ажил, үүргийн чиглэлээр байгуулсан харьяа салбар зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална”

судалдаг, энэ талаар сургуулийн удирдлагын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлдэг” гэсэн тайлбарыг өгч байгаа боловч үүнийг нотлох баримт байхгүй байна. Аудитын явцад орон нутаг дахь салбар зөвлөлийн 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ирүүлсэн боловч баталгаажуулах, тухайн жилийн эцэст төлөвлөгөөг хэрэгжүүлсэн эсэх талаарх ажлын тайлан байхгүй байна. Энэ нь орон нутгийн салбар зөвлөл нь хэвийн үйл ажиллагаагүй, хийж хэрэгжүүлсэн ажил нь тодорхойгүй байгаа нь зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Мөн МСҮТ-ийн сургалтын албаны даргын албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын байрны чиг үүрэгт хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, төлөв байдлын шинжилгээ хийх, шинээр элсэлт авах мэргэжлийн судалгаа гаргах, нийгмийн түншлэл хариуцсан ажилтны чиг үүрэгт хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, сургалтын байгууллагын хүчин чадалд үндэслэн элсэлтийг зохион байгуулах зэрэг ажлууд тусгагдсан байгаа боловч хэрхэн хийгдсэн талаар баримт байхгүй, хийсэн ажлыг нотлох боломжгүй байна.

Энэ талаар холбогдох албан тушаалтнаас тодруулахад “аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн суурь судалгаа байхгүй учир эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ, судалгаа хийх боломжгүй, нийгмийн түншлэл хариуцсан ажилтан тогтворгүй байдаг” гэсэн тайлбарыг өгч байна. Энэ нь мэргэжлийн боловсролыг олгох сургалтын элсэлтийг зохион байгуулах судалгааны ажил орхигдож, хуульд заасан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгад нийцсэн байх гэсэн үндсэн шаардлагын нэг хэсгийг хангахгүй байна.

2.2 Аймгийн хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжил олгож байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёлыг төлөвшүүлэхэд оршино гэж мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд тодорхойлсон байна.

Аймгийн МСҮТ-өөс 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол, сургалтыг нийт 14 мэргэжлээр 486 суралцагч, богино хугацааны сургалтыг 2 мэргэжлээр зорилтот бүлгийн 32 иргэн тус тус суралцаж төгссөн байна. /Дүрслэл №1/

Төгсөгчдийн тоо мэдээ

/Дүрслэл №1/

2017-2018 оны хичээлийн жил	•Мэргэжлийн боловсрол 7 мэргэжлээр 138 төгсөгч •Мэргэжлийн сургалт 4 мэргэжлээр 80 төгсөгч
2018-2019 оны хичээлийн жил	•Мэргэжлийн боловсрол 4 мэргэжлээр 81 төгсөгч •Мэргэжлийн сургалт 10 мэргэжлээр 187 төгсөгч •Богино хугацааны сургалт 2 мэргэжлээр 32 төгсөгч

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчдөөс 2017-2018 оны хичээлийн жилд төгссөн 42 суралцагч, 2018-2019 оны хичээлийн жилд төгссөн 11 суралцагч дараагийн шатны сургуульд үргэлжлүүлэн суралцсан байна.

Мөн 2018-2019 оны хичээлийн жилд ХНХЯ-аас малчин, хүлэмжийн аж ахуйн фермерийн мэргэжлийн ангийг нээх чиглэлийг өгснөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Малжуулах” төсөлд хамрагдсан 20 иргэн, хувиараа хүнсний ногоо тариалдаг 14 иргэнийг хамруулан сургасан байна.

Үүний зэрэгцээ аудитын хамрах хугацаанд зэвсэгт хүчний 336-р анги, хилийн цэргийн 0129-р ангиудын захиалгаар автомашин засварчин, барилгын өрөг угсрагч, мужаан зэрэг мэргэжлийн сургалтыг зохион байгуулж, нийт 98 цэргийн алба хаагч суралцсан байна.

Аймгийн МСҮТ-ийг 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн судалгааг /үндсэн ангийн тоо үзүүлэлтээр/ аймгийн ХХҮГ-аас ирүүлсэн тухайн жилийн ажил олгогчийн ажлын байрны захиалгатай харьцуулан үзэхэд дараах байдалтай байна. /Хүснэгт №10/

Ажлын байрны захиалгын тоог МСҮТ-ийг төгсөгчдийн тоотой харьцуулсан үзүүлэлт

/Хүснэгт №10/

№	Мэргэжлийн нэр	2017-2018 оны хичээлийн жил			2018-2019 оны хичээлийн жил		
		Төгсөгчийн тоо	Ажлын байрны захиалга	Зөрүү	Төгсөгчийн тоо	Ажлын байрны захиалга	Зөрүү
1	Тогооч	44	14	30	18	29	-11
2	Барилгын мэргэжил	26	43	-17	24	20	4
3	Автомашин засварчин	14	22	-8	15		15
4	Гагнуурчин	19	7	12	15	1	14
5	Барилгын цахилгаанчин	10	34	-24	14	7	7
6	Бэлэг дурсгалын зүйл урлаач	4		4			0
7	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	16		16	12		12
8	Хүнд машин механизмын оператор	15	39	-24	17	81	-64

9	Хангамжийн нярав	9	12	-3	13	11	2
	Дүн	157	171		128	149	

/Жич: Үргэлжлүүлэн суралцсан төгсөгчдийг хассан дүнгээр төгсөгчдийн тоог тооцов/

Судалгаанаас харахад тухайн жилийн онцлогоос хамааран зарим мэргэжилтэй ажилчдын ажлын байрны захиалга эрэлттэй байхад зарим ажлын байрны захиалга огт байхгүй байх үзүүлэлттэй байна. Тухайлбал уул уурхайн, барилгын компаний үйл ажиллагаа идэвхтэй байх эсэхээс шалтгаалан тухайн мэргэжлийн ажилтан болон тогоочийн ажлын байрны захиалга их байна. Харин оёмол бүтээгдэхүүний оёдолчин, бэлэг дурсгалын зүйл урлаачийн ажлын байрны захиалга байхгүй байгаа талаар судлахад аймгийн хэмжээнд оёдлын томоохон үйлдвэр байхгүй, хувийн ААНБ нь цөөн, ихэвчлэн хувь хүн дангаар үйл ажиллагаа явуулдагтай холбоотой байна.

Мөн БСШУС-ын 2016 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс”, МБСҮЗ-ийн 2017 оны 02 дугаар тогтоол, 2018 оны 02 дугаар тогтоолоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх “Ажил мэргэжлийн лавлах”-ыг баталсан байна. Аймгийн ХХҮГ-аас ирүүлсэн ажлын байрны захиалгад ажил мэргэжлийн лавлахад тусгагдсан зарим мэргэжилтэй ажилчид эрэлт хэрэгцээтэй байна. Тухайлбал:

- Уул уурхайн зарим мэргэжилтэн
- Сувилагч
- Малын эмч
- ЕБС болон СӨБ –ийн багш
- Байгаль орчны мэргэжилтэн
- Нягтлан бодогч зэрэг байна.

Эдгээр мэргэжлүүд нь дээрх эрх зүйн баримт бичигт тусгагдсан байгаа учир мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх боломжтой юм.


Гэвч сургуулийн төсөв санхүү, мэргэжлийн багшлах боловсон хүчин, хичээл дадлагын хэрэглэгдэхүүн, сургалтын орчин нөхцөл бүрдээгүй байдал зэргээс шалтгаалан хичээллэх боломжгүй, тусгай зөвшөөрөл хүсэх нөхцөл шаардлага бүрдээгүйтэй холбоотой байна. Харин 2018-2019 онд архив, бичиг хэргийн ажилтны ажлын байрны захиалга эрэлттэй байгаад үндэслэн “нарийн бичгийн дарга, бичиг хэргийн ажилтан” бэлтгэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг ХНХЯ-д хүргүүлсэн боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа байхгүй учир зөвхөн аймгийн ХХҮГ-т бүртгэлтэй ажлын байрны захиалгаар эрэлт хэрэгцээг бүрэн тодорхойлох боломжгүй байна.

2.3 Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 26 хувь нь ажлын байраар хангагдаагүй байна.


Мэргэжлийн сургалтын байгууллага нь аудитын хамрах хугацаанд суралцагчдыг төгссөнөөс хойших 3, 6, 12 сарын байдлаарх ажил эрхлэлтийн судалгааг хийсэн байна. Мөн 2019-2020 оны хичээлийн жилд 2017-2019 онд төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдалд судалгаа хийж, 2020 оны байдлаар нийт төгсөгчдийн 46.1 хувь /3 жилийн дунджаар/ нь тодорхой ажил эрхэлж байгаа гэж дүгнэжээ.

Аудитаар МСҮТ-ийн 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсролын үндсэн ангийг төгссөн 80 төгсөгчидтэй болон гэр бүлийн гишүүдтэй нь холбогдож ажил эрхлэлтийн байдлыг судаллаа. /График №2/ Судалгаанд хамрагсдын 35 хувь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа бол 10 хувь мэргэжлийн бус ажил эрхэлж, 26 хувь тодорхой ажилгүй байна.



Үүний шалтгааныг тодруулахад орон нутагт ажлын байр хангалтгүй байдагтай холбон тайлбарлаж байна. Манай аймгийн хувьд сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалтын ажил хийгдэж барилга байгууламж ихээр баригдсан ч гэрээгээр мэргэжлийн бригад ажиллуулах, ажлын туршлага шаардах байдал түгээмэл байдаг байна. Мөн зарим төгсөгчид насанд хүрээгүй байгаа нь ажилд авахгүй байх үндэслэл болдог, туслах ажилтны түр ажлын байр ихэвчлэн олддог, улирлын шинж чанартай тул тогтмол ажлын байр хангалтгүй байдаг зэрэг шалтгаан тайлбарыг өгч байна.

Судалгаанд хамрагсад мэргэжлийн ангид элсэн орохдоо ажлын байрны хангалттай байдлын талаар судлаагүй, зөвхөн өөрийн сонирхлоор элсэн суралцсан байдал нь дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь төгсөөд гарахад мэргэжлийн ажил олдохгүй байх эрсдэлийг бий болгож байна. Ажилгүй байгаа төгсөгчдийн мэргэжлийн авч үзэхэд барилга, гагнуурын мэргэжлээр илүүтэй байна. /судалгаанд хамрагдсан төгсөгчдийн дүнгээр/



Аймгийн МСҮТ-д элсэн орж байгаа суралцагчдын насны бүтцийг авч үзэхэд нийт суралцагчдын 35-40 хувь 14-15 настай байна. Энэ нь эдгээр суралцагчид мэргэжлийн боловсрол эзэмшээд төгсөхөд 16-17 настай байдаг ба эрх зүйн бүрэн бус чадамжтай байгаа нь ажил эрхлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж

байна. Учир нь Хөдөлмөрийн тухай хуулиар 18 нас хүрээгүй иргэний ажлын байрны нөхцөлөөс шалтгаалан ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ажил олгогч нар ажилд авахад хүндрэлтэй байдаг байна. Мөн эрэгтэй суралцагчид 18 нас хүрээд төгсөж цэрэгт татагдсан нь ажилгүй гэсэн үзүүлэлтэд нөлөөлж байна. /График №3/

Судалгаанд хамрагсад мэргэжлийн ур чадварын хувьд хэдийгээр тодорхой ААНБ-д байгууллагад ажил эрхэлдэггүй ч зарим үед бусадтай хамтран мэргэжлийн ажил хийх, өөр ажил хийсэн ч эзэмшсэн мэргэжлээрээ хувь нэмрээ оруулах зэрэг давуу талтай байдаг гэсэн тайлбарыг өгч байна.

Мөн МБСҮЗ-ийн орон нутгийн салбар зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүрэгт төгсөгчдийг ажлын байртай холбоход шууд дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй⁴ гэж заасан байна. Гэтэл энэ талаар тодорхой хийгдсэн ажил байхгүй, холбогдох нотлох баримт байхгүй, үйл ажиллагаагаа хэрхэн явуулдаг нь тодорхойгүй байна.

2.4 Мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1⁵-д тус хуулийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хяналтыг тавина гэж заасан байна.

Аймгийн мэргэжлийн хяналтын газраас 2018 онд МХЕГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн лаборатори, дадлагын газрын тоноглол, хичээл дадлагын ажлын зохион байгуулалтад тандалт судалгаа хийсэн байна. Судалгаанд аймгийн МСҮТ болон төмөр замын МСҮТ-ийг хамруулжээ. Хяналт шалгалтын танилцуулгаар хичээлийн лаборатори, дадлагын байруудын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, зохион байгуулалт зэрэг чиглэлээр суралцагчдаас асуулга, шаардлагатай асуудлаар санал авч нэгтгэн хүргүүлсэн байна. Мөн тандалт судалгааны ажлын хүрээнд багшлах эрхгүй 8 багш байгааг

⁴ “МБСҮЗ-ийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн дүрэм”-ийн 3.10 “Орон нутгийн салбар зөвлөл нь суралцагчдыг дадлагын байраар хангах, төгссөн суралцагчдыг ажлын байртай холбоход шууд дэмжлэг туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй”

⁵ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

шийдвэрлэх болон үндсэн багшийн орон тоо нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар тусгасан хяналт шалгалтын танилцуулгыг хүргүүлсэн байна.

Харин мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагаа, элсэлтийг хэрхэн авч байгаа, төгсөгчид ажлын байраар хангагдсан эсэх, сургалт явуулах үйл ажиллагаа нь хуулийн зорилго зорилтыг хангаж чадаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөн аймгийн МСҮТ-ийн батлагдсан бүтэц орон тооны дагуу хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажилтны албан тушаалын тодорхойлолтын чиг үүрэгт байгууллагын дотоод аудитыг хэрэгжүүлэхээс гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна гэж тусгасан байна. Байгууллагын 2018-2019 оны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын тайланг авч үзэхэд байгууллагын дотоод үйл ажиллагаа, багш нарын хөтлөх баримт бичиг, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зарим асуудал, шилэн дансны цахим хуудас хөтлөлт, суралцагчдын хичээл таслалт, дотуур байрны үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт зэрэгт хяналт шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлэн ажилласан байна. Харин мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, огт үнэлгээ хийгдээгүй байна.

Дээрх байдал нь мэргэжлийн боловсролын байгууллагын зорилго, зорилт, сургалтын үр дүн, ажлын байрны болон ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжил, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргаж чадаж байгаад тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Сургалтын орчин болон тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалттай байна.
- Зарим мэргэжлийн багшлах боловсон хүчин дутагдалтайгаас эрэлттэй болон захиалгат мэргэжлээр боловсрол олгож чадахгүй байна.
- Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2018 онд 5,206.5 мянган төгрөг, 2019 онд 3,580.8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Хичээл үйлдвэрлэлийн зардлыг зориулалт бусаар зарцуулснаас зарим дадлагын хэрэглэгдэхүүнийг суралцагч өөрөө гаргаж байна.
- Дорноговь аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийгдээгүй байна.
- Мэргэжлийн боловсролыг иргэний хөдөлмөрлөх хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн олгож байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг судлаагүй байна.
- Аймгийн МСҮТөвийг 2017-2019 онд төгссөн суралцагчдын ажил эрхлэлтийн байдал 46.1 хувьтай байна.
- МБСҮЗ-ийн Дорноговь аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа тогтмол бус, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа байхгүйгээс ХХҮГ-т бүртгүүлсэн ажил олгогчийн захиалгаар мэргэжилтэй ажилтны эрэлт хэрэгцээг тодорхойлоход хүрч байна.
- Аймгийн МСҮТ-ийн сургалтын албаны дарга, нийгмийн түншлэл хариуцсан ажилтан нар албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Хөдөлмөрийн зах зээлд эрэлт, хэрэгцээтэй мэргэжлээр боловсрол олгож байгаа эсэх болон төгсөгчдийн ажил эрхлэлтэд эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар нийт 8.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 2 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

ЗӨВЛӨМЖ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төсөвт биеийн тамирын уралдаан, тэмцээний зардлыг баталдаггүйгээс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг зориулалт бусаар зарцуулж, Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан эдийн засгийн ангилалыг зөрчих зөрчил удаа дараа гарч байна. Иймд дээрх зардлыг байгууллагын төсөвт тусгаж батлаж байх талаар ХНХЯ болон Сангийн яаманд уламжилж өгнө үү.

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ Б.АДИЛБИШ ТАНАА.

1. Сургалтын албаны дарга, нийгмийн түншлэл хариуцсан ажилтан нарын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлж зах зээлийн төлөв байдлын шинжилгээ хийх, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг судлан төгсөгчдийн ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах, шинээр элсэлт авах мэргэжлийн судалгаа хийх, судалгаанд үндэслэн элсэлтийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛД.

1. “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн дүрэм”-ийн гурав дахь хэсэгт заасан орон нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилчдын эрэлт хэрэгцээг үнэн зөв, бодитоор тогтоох, ААНБ-ын захиалгыг судалж шинээр элсүүлэх захиалгын саналыг мэргэжил бүрээр гарган МСҮТ-тэй хамтран ажиллах, төгссөн суралцагчдыг ажлын байртай болоход дэмжлэг үзүүлэх гэсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

ДОРНОГОВЬ АЙМАГ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Утас/факс: (705) 2-24-92 И-мэйл: dga.msut@yahoo.com <u>2020.06.29</u> № <u>79</u> танай <u>2020.06.29</u> -ны № <u>1-6/505</u> -т	ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ
--	-----------------------

Санал хүргүүлэх тухай

Тус сургууль дээр “Мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааны үр дүн”сэдэвт аудитыг үндсэн 2 бүлгээр хийж гүйцэтгэн тайланг төслөөр ирүүлснийг хүлээж авч танилцаад дараах санал, тайлбарыг хүргүүлж байна.

1 дүгээр бүлгийн 1.3 дээрх хичээл үйлдвэрлэлийн зардлаас 8.787.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан талаар тайлбар:

Сангийн яамнаас мэргэжлийн боловсролын салбарын төсвийг биеийн тамирын болоод бусад ур чадварын уралдаан тэмцээнүүдэд багш, оюутнууд оролцох, гэрчилгээ, тэмдэгтийн хураамжийн зардал гэж тусгай ангилалд оруулж баталдаггүй тул Сургуулийн Удирдах Зөвлөлийн хурлаар хичээл үйлдвэрлэлд хуваарилагдаж ирсэн нийт зардлыг хэлэлцүүлж шийдвэр гаргуулдаг.

Хичээл үйлдвэрлэл, уралдаан тэмцээн, багш сургах, багаж хэрэгсэл, ном хэвлэл худалдан авах таван төрлөөр хуваарилалт хийж, Удирдах зөвлөлийн тогтоол гарган хэрэгжүүлэн ажилладаг. Энэхүү эрх нь Техникийн болон Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмээр эрх зүйн орчин нь зохицуулагдсан байдаг.

/Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/19 тоо тушаалын хоёрдугаар хавсралт 3.1.4-д зааснаар хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг батлах, зарцуулалтанд хяналт тавих/

2018, 2019 оны Сургуулийн Удирдах Зөвлөлийн тогтоолоор тухайн онууд дах хичээл үйлдвэрлэлийн зардал хуваарилалтын дагуу зарцуулагдсан байх тул батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан гэдэгтэй санал нийлэхгүй байгаагаа үүгээр илэрхийлж байна.

Тайлангийн төслийн 25 дугаар хуудсанд Зөвлөмж 1-д тайлбар хүргүүлэх нь: МБС-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-ийг дагаж мөрдөөгүй тухайд.

Тус сургууль нь хичээлийн жилд улсын төсөвт 8.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсэн байдаг. Үйлдвэрлэлийн дадлагад зориулан зарцуулсан зардлыг эцсийн бүтээгдэхүүн болгож, борлуулалт хийснээр дээрх орлогыг бүрдүүлж ажилладаг ба сургууль суралцагсдаас нэмэлт орлого төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулалтай хийж, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авсан тохиолдол байхгүй. Зарим шаардлагатай мэргэжлүүд тухайн хичээлийн агуулгыг бүрэн эзэмшүүлж, ур чадвар олгох тал дээр суралцагсдаас бага хэмжээний материалын зардал гаргуулсан байх нь хичээл үйлдвэрлэлийн зардал хүрэлцдэггүйтэй холбоотой тул дээрх зөвлөмжийг хүлээн авах боломжгүй байна.

ЗАХИРАЛ


Б.АДИЛБИШ



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 79 дугаар албан бичгээр ирүүлсэн саналтай дараах тайлбарыг өгөв. Үүнд:

1. Тайлангийн 1.3 дахь хэсэгт “ ... хичээл үйлдвэрлэлийн зардлаас 8,787.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна” гэж тусгасныг 2018 оны төсвийн төсөлд биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд 8,340.9 мянган төгрөг, 2019 онд 14,707.4 мянган төгрөгийг тус тус төлөвлөн, төсвийн төсөл тооцож хүргүүлсэн боловч тухайн жилийн төсөвт тус зардлыг баталж өгөөгүй байна. Иймд биеийн тамирын уралдаан, тэмцээний зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас зарцуулсан байна. Энэ нь төсвийг зориулалт бусаар зарцуулах шалтгаан болсон тул албан шаардлага тогтоохгүй байхаар шийдвэрлэв.
2. Тайлангийн зөвлөмж хэсгийн 1-д “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17дугаар зүйлийн 17.1-д “суралцагч сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй” гэж заасны дагуу суралцагсдаас сургалтын хэрэглэгдэхүүн болон түүнийг худалдан авах зорилгоор төлбөр төвлөрүүлэхгүй, хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргах” гэж тусгасныг хичээл үйлдвэрлэлийн зардлаас хичээлийн хэрэглэгдэхүүн, материалыг худалдаж авахад төсөв хүрэлцдэггүй нөхцөл байдлыг тооцож зөвлөмжөөс хасав .

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР

Б.УРАНБИЛЭГ

АУДИТОР

У.ОЮУНТҮЛХҮҮР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.ХЭРЛЭНЧИМЭГ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/20

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйл, 20 дугаар зүйлийн 20.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, 2018 оны А/207 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захиралд зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд хүргүүлсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА